

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН 2023 ОНЫ НӨХӨН БОЛОН ДАХИН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН
ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ, НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

АУДИТЫН КОД: СЭА-2023/51-13-ШТА-НА



Сүхбаатар сум
2023 он

Энэхүү аудитын тайлангийн төсөлтэй холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа
Утас: 70363040, Цахим хаяг:

Enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх
Утас: 70363036, Цахим хаяг:

Batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Отгонбаяр

Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.com

Аудитор Д.Чулуунцэцэг Цахим хаяг:

Chuluuntsetsegd@audit.gov.com

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АН	Ардчилсан нам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАН	Монгол Ардын нам

АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудитын нэр:

Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх.

Аудитын код: СЭА-2023/51-13-ШТА-НА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго:

Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд өгсөн аудитын дүгнэлт, дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга болон бусад шаардлагатай баримт материалуудыг хамруулан хэрэгжүүлэв.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн гаргасан Монгол Улсын Төрийн аудитын стандарт /MNS:6817-1:2020 “Төрийн аудит.Тулгуур зарчим”-д заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2020 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/17 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг үндэслэн нэр дэвшигчийн өөрийн болон намаас оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйлсийг цуглуулж, тайланг бэлтгэв.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- Сэлэнгэ аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/9, А/10 дугаар тушаалаар баталсан "Аймаг, сумдын ИТХ-ын сонгуулийн тойрогт нам, нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээ"
- Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2020 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/17 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам";
- Холбогдох бусад хууль эрхийн актууд.

Аудит хийх хугацаа, багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, аудитор Д.Чулуунцэцэг нар 2023 оны 9 дүгээр сарын 01-ээс 9 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д заасны дагуу Баруунбүрэн, Сүхбаатар сумдад сумын ИТХ-ын нөхөн сонгуулийг 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдөр явуулах шийдвэрийг СЕХ-ноос гаргасан байна.

Орон нутгийн 2023 оны нөхөн сонгуулийн 3 тойрогт 2 намаас болон бие даагч нийт 7 нэр дэвшигч оролцсон байна. Үүнд:

Хүснэгт 1

Д/д	Намын нэр	Нам	Нэр дэвшигчид
1	МАН	1	3
2	Ардчилсан нам	1	3
3	Бие даан нэр дэвшигч		1
Нийт		2	7

Орон нутгийн 2023 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын тайлан ирүүлсэн 3 нэр дэвшигчийн дансанд нийт 4,143.3 мянган төгрөгийн орлого төвлөрснөөс сонгуулийн үйл ажиллагааны зардалд 3,173.3 мянган төгрөг зарцуулж, 50.0 мянган төгрөгийн хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаан, 920.0 мянган төгрөгийн хүлээн зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг зарцуулсан байна.

Сонгуульд өрсөлдсөн 2 нам болон 4 нэр дэвшигч нь нөхөн сонгуультай

холбоотой зардлын данс нээгээгүй байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/9, А/10 дугаар тушаалаар "Аймаг, сумдын ИТХ-ын сонгуулийн тойрогт нам, нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээ"-г тогтоон нийтэд мэдээлснийг нам, нэр дэвшигчид хэтрүүлээгүй байна.

1. Сонгуулийн зардлын дансны орлого, зардал

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д "Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй" гэж заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг сумын ИТХ-ын нөхөн сонгуульд оролцсон МАН болон АН намаас нэр дэвшигч 2, бие даан нэр дэвшигч 1 зэрэг нийт 3 зардлын дансны мэдээллийг ирүүлсэн бол 2 нам, 4 нэр дэвшигч зардлын данс нээлгээгүй байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д "Нам эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ" гэж заасан байдаг.

Орон нутгийн хурлын нөхөн сонгуульд оролцож зардлын данс нээлгэсэн 3 нэр дэвшигч зардлын тайланд хийсэн аудитын дүгнэлтээ хуулийн хугацаанд бүрэн ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д "Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ" гэж заасны дагуу сонгуулийн зардлын данс нээлгэсэн 3 нэр дэвшигчийн дансны хуулгыг Хаан банк, Төрийн банк бүрэн ирүүлсэн байна.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт 4,143.3 мянган төгрөгийн орлогоос 4,140.0 мянган төгрөг нь мөнгөн хандив, 3.3 мянган төгрөг нь нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө байна. /Хавсралт 1-д дэлгэрэнгүй харуулав. /Үүнд:

Хүснэгт 2

Орлогын төрөл	Орлого /мянган төгрөг/				Нийт	
	Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Тоо	Дүн
Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө						
Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	2	3.3			2	3.3
Хуулийн этгээдийн хандив						
Иргэний хандив	14	4,140.0			14	4,140.0
Дүн	16	4,143.3			16	4,143.3

Орон нутгийн 2023 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдэд хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандивыг өгсөн иргэн байхгүй байна.

Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 4,143.3 мянган төгрөг зарцуулснаас сонгуулийн сурталчилгааны зардалд 2,270.0 мянган төгрөг, үйл ажиллагааны зардалд 800.0 мянган төгрөг, бусад зардалд 1,073.3 мянган төгрөг зарцуулсан байна. /Хавсралт 2-д дэлгэрэнгүй харуулав. / Үүнд:

Хүснэгт 3

Зардлын ангилал		Мөнгөн дүн /мянган төгрөг/
2	Нийт зардлын дүн	4,143.30
2.1	Сонгуулийн зардлын дүн	3,070.00
2.1.1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	2,270.00
2.1.2	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах	
2.1.3	Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	
2.1.4	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	
2.1.5	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	800.00
2.1.6	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	
2.1.7	Цахим орчин ашиглах зардал	
2.1.8	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	
2.2	Бусад зардлын дүн	1,073.30

МАН болон АН нь орон нутгийн хурлын нөхөн сонгуультай холбоотой банкинд данс нээгээгүй бөгөөд мөнгөн болон мөнгөн бус хандив аваагүй байна.

2. Хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандив:

Орон нутгийн 2023 оны нөхөн сонгуульд оролцсон 2 нэр дэвшигч нь хандив өгч буй иргэний нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй зэрэг шалтгаантай 12 иргэний 970.0 мянган төгрөгийн хуулиар зөвшөөрөөгүй хандив тайлагнасан байна.

Үүнээс 1 иргэнийн 50.0 мянган төгрөгийн хандивыг буцааж, 1 нэр дэвшигч нь 11 иргэний 920.0 мянган төгрөгийн хандивыг зарцуулсан байна.

3. Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Аудитын хуулийн этгээд нь Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2020 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/17 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын дагуу аудит хийж баталгаажуулсныг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар дахин хянаж, баталгаажууллаа.

Аудитын хуулийн этгээдийн дүгнэлтээр Сүхбаатар сумын ИТХ-д бие даан нэр дэвшигч О.Золзаяа нь 11 иргэний хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй / хандив өгч буй иргэний нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу / 920.0 мянган төгрөгийн хандивыг зарцуулсан зөрчил илэрлээ.

4. Аудитын дүгнэлт:

Орон нутгийн 2023 оны нөхөн сонгуульд оролцож, данс нээсэн Сүхбаатар сумын 3 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар дүгнэлт гаргасан байна.

Дүгнэлт гаргасан аудитын хуулийн этгээд нь нэр дэвшигчдийн зардлын 3 буюу бүх тайланг үнэн зөв, иж бүрэн илэрхийлсэн байна.

5. Зөвлөмж:

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга П.Эрдэнэсайханд:

- Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4-т заасныг зөрчин, шаардлага хангаагүй хандивын орлогыг буцаалгүй зарцуулсан Сүхбаатар сумын ИТХ-ын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч О.Золзаяад Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21-д заасны дагуу арга хэмжээ авах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Ц.ОТГОНБАЯР

